

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 193 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Үнэлгээний ажлыг зохион байгуулахад шаардлагатай бичиг хэрэг, холбоо, техник хэрэгсэл, сумд очиж ажиллах, нэгтгэл тайлан хэвлүүлэх зэрэг зардлыг тооцож орон нутгийн 2018 оны төсвийн төсөлд тусгуулах саналаа өгсөн.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймаг сум дахь газрын бүсчлэл, зориулалт, үнэлгээ, татвар хураамжийн талаар мэдээлэл авсан.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга эрхлэгч, захирал нарт Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 10 сарын 05-ны өдрийн 403 албан тоотор орон нутгийн хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар эзэмших, ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн 2016 оны жилийн эцсийн дүнгээрх судалгаа гаргах, дүн шинжилгээ хийх, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд хамрагдах барилга, байгууламж, худаг, зам, гүүр, нийтийн эзэмшлийн байгууламжийн хувийн хэрэг, хийц хэмжээсийн бүртгэл, хөрөнгийн зураг, байршлын схем бусад холбогдох бичиг баримтыг иж бүрэн гаргаж, бэлтгэх, газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын болон байршлын зураг, холбогдох шийдвэр зэрэг бичиг баримтыг иж бүрэн гаргаж, бэлтгэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгч ажиллаж байна.

3. Концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам, гүүрийн байгууламж, тоног төхөөрөмж болон бусад концессын зүйлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, төрийн өмчийн бүртгэлд тусгах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлж байхыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай.

2016 онд концессын гэрээний дагуу Улиастай сумын Өлзийт, Жинст багуудад барьж байгуулсан тус бүр нь 320,0 сая төгрөгийн өртөг бүхий “Иргэдийн хөгжлийн төв”-ыг хууль тогтоомжийн дагуу хүлээн авч Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын дансанд, Улиастай сумын Жинст, Чигэстэй, Товцог багуудын гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн шинэчлэлийн ажлын нийт 52,318,000 төгрөгийн гэрэлтүүлгийг Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны дансанд бүртгэсэн байна. Мөн Эрдэнэхайрхан сумын Товхош уул, Дөрвөлжин сумын Бага буурал уул, Баянтэс сумын Бужир ууланд “Гар утасны дахин дамжуулах тоног төхөөрөмж суурилуулах, дэд бүтэц бий болгох, үүрэн холбооны G-Mobile үйлчилгээ оруулах” ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 180,0 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд тусгаагүй байна.

2017 онд концессын гэрээгээр ажил хийгдээгүй байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр барьж байгуулсан барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин техник зэрэг хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2016 онд 173,982,857 төгрөгийн машин техник хэрэгсэл, 2,272,890,627 төгрөгийн барилга байгууламж, 253,105,300 төгрөгийн тоног төхөөрөмж /эд хогшил/-г орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэсэн байна. 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр барьж байгуулсан барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин техник зэрэг хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

7. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран авч хэрэгжүүлэн, нэгдсэн дүнг 2017 онд багтаан Засгийн газарт оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж дараах шийдвэр гарсан байна. Үүнд Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх-7 тогтоол /15 байгууллагын 269,029,698 төгрөгийн хөрөнгө шилжүүлэх/, Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох-3 /17 байгууллагын 24 ширхэг хөрөнгө худалдах/ Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох-2 тогтоол /3 байгууллагын 33,520,000 төгрөгийн хөрөнгө бэлтгэх/ Хөрөнгө актлах-6 тогтоол /31 байгууллагын 722,383,459 төгрөгийн хөрөнгө актлах/

8. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах, дуусаагүй барилга байгууламжийг судлан хууль тогтоомжийн дагуу зохих шийдвэр гаргахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор 8 байгууллагын 10 ширхэг тээврийн хэрэгсэлийн гэрчилгээ нь аж ахуй нэгж байгууллага, хувь хүний нэр дээр бүртгэлтэй байсан зөрчил гарсан. Уг зөрчлийг арилгах талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгож зөрчлийг арилгасан болно.

Тэс сумын Засаг даргын Тамгын газрын Дуусаагүй барилга байгууламжийн дансанд 19,795,556 төгрөгийн өртөг бүхий Конторын барилгын зураг төслийг бүртгэсэн. Уг барилга санхүүжилт байхгүй улмаас баригдаж эхлээгүй байна. Өөрөөр манай орон нутгийн өмчлөлд бүртгэлтэй дуусаагүй барилга байхгүй.